

БАГШЛАХ ХЭВ МАЯГИЙГ СУДАЛСАН БАЙДАЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

П.Алтанцэцэг, магистр, Э.Мөнхбат, магистр, МУБИС

Abstract: A.F. Grasha determined advantages and disadvantages of teachers teaching styles in his research. There are 5 teaching styles, the teacher as Expert, formal authority, personal model, facilitator and delegator. 75 teachers of Ulaanbaatar city and rural area have participated in this research. 40 questions were asked to teachers by the researcher in April, 2015. Received answers are evaluated using A.F. Grasha's questionnaire. Questions are interpreted with the help of SSPS20 program to determine the percentage rates. The results of the study shows:

- Teachers have all teaching styles. Most of the teaching styles, / the teacher as expert-73.3 %, authority-52%, facilitator-52%, personal model-66.7%, delegator-81.3% / are in average and high levels
- Teachers with 1 to 5 and 11 to 20 years of experience possess knowledge and expertise that students need. Oversees, guides, and directs by showing how to do things. They focus on clear expectations and acceptable ways of doing things.
- Teachers with more than 25 years of experience have teaching style; the teacher as expert 100%, delegator-87.5%, formal authority-75%. Teachers with more than 25 years of experience provide much support and encouragement more than other teachers.

Түлхүүр үг: шинжээч, албархаг, үлгэрлэгч, чиглүүлэгч, гүйцэтгүүлэгч

Удиртгал

Боловсролын шинэчлэлийн гол өөрчлөх зүйл нь багш нар, тэдний үйл ажиллагааны арга барил, хэв шинж мөн. Сургалтын гол зорилго болсон сурагчийн сурах аргыг бие даан эзэмшүүлэхэд багшийн багшлахуйн хэв шинж чухал нөлөөтэй болохыг тодруулах шаардлагатай байна. Судалгаанд хот хөдөөгийн ЕБС-ийн 75 багшийг хамруулсан бөгөөд 40 асуулт бүхий асуулгаар судалгаа авч үр дүнг боловсрууллаа. Судалгааны зорилго нь ЕБС-ийн багш нар багшлах ямар хэв шинжтэйг илрүүлэн судлахад оршино.

Үндсэн хэсэг

Багш мэргэжлийн гол зорилго нь хүүхэд залууст амьдралд нь хэрэгтэй мэдлэг, арга барил, чадвар, дадал эзэмшүүлж төлөвшүүлэх замаар хүний хөгжлийн хэрэгцээнд нийцсэн чанартай боловсролоор үйлчлэхэд оршино. Орчин үеийн боловсролын дэвшилтэт үзэл баримтлал болон нийгмийн хэрэгцээ шаардлагын дагуу боловсролын шинэчлэлийн гол цөм болсон багш нар багшлах үйл ажиллагааны агуулга аргагүйгээ өөрчлөн “сайн багшийн” хэв шинжийг өөртөө шингээх нь нэн чухал болж байна.

Сургалтыг удирдан явуулахад багшийн гол үүрэг нь суралцагчдаар мэдлэг бүтээлгэх, тэдний чадварыг хөгжүүлэх, эерэг хандлага төлөвшүүлэх явдал бөгөөд мэдлэг чадварын ялгаатай байдлыг

үл харгалзан хичээлийг үр дүнтэй болгохыг зорьдог.

Иймээс орчин үеийн сургалт нь багшаас өндөр ур чадвар бүхий хэв шинжийн арга барилыг шаардаж байна. Судлаач Антони Граша өөрийн судалгаан дээр үндэслэн багш нарыг багшлах ур чадвар, хэв маягаараа ялгаатай болохыг тодорхойлжээ. Тэрээр багшлах хэв шинжийг “Шинжээч”, “Албархаг”, “Үлгэрлэгч”, “Туслан дэмжигч”, “Бусдаар гүйцэлдүүлэгч” гэж ангилж үзжээ (Граша, 1984, х.46, 53).

Эдгээр хэв шинжийг тус бүрд нь авч үзвэл:

Шинжээч багш: Мэдлэг туршлагатай, суралцагчдаа хянаж, тэднийгээ удирдан залж чиглүүлдэг, мэдлэгээрээ нэр хүнд байр сууриа олж авдаг, баримт мэдээлэлд илүү тулгуурладаг. Ийм хэв маягийн сурган хүмүүжүүлэгчийн эзэмшсэн мэдлэг мэдээлэл нь давуу тал болдог. Мэдлэгээ хэтрүүлэн ашигласнаар суралцагчдад айдас төрүүлдэг (Граша, 1992, х. 142, 149).

Албархаг хэв шинж: Ийм хэв шинжийн багш нар суралцагчийнхаа дунд мэдлэг болон эрх мэдэл бүхий албан тушаалаараа нэр хүнд байр сууриа олж авдаг. Сургалтаа явуулахдаа “уламжлал” болон стандартыг дагаж мөрддөг. Суралцагчдаасаа ихийг хүсэн хүлээнэ. Сургуулийн болон бусад дүрэм журамд илүү их ач холбогдол өгнө.

Суралцагч стандарт үйл ажиллагаа үйлдэл, алхам бүрийг хэрхэн биелүүлж буйд шүүмжлэлтэй хандаж хянадаг. Асуудалд уян хатан биш, нэлээд хатуу чанга хандах байдалтай.

Үлгэрлэгч хэв шинжтэй багш: манлайлж тэргүүлдэг, суралцагчдаа яаж хийхийг үзүүлдэг, зөвлөдөг, аливаа зүйлийг хэрхэн хийхийг үзүүлж харуулдаг. Суралцагчаа ажиглан дуурайж гүйцэтгэхийг дэмждэг байна. Суралцагчийг өөрийн төсөөллөөр “хэт дуураймал” болгох гэсэн хүсэл давамгайлж болзошгүй.

Туслан дэмжиж чиглүүлэгч хэв шинж нь сургах ба суралцахуйн харилцаанд хувь хүний үүднээс хандах ёстойг чухалчилдаг бөгөөд шавь нарт нь ямар сонголт байгааг мэдрүүлдэг, тэднийг бие дааж суралцах үүрэг хариуцлага, бие даасан байдал, идэвх оролдлого зэргийг ихэд анхаарч тусалж ажилладаг. Хувь хүний уян хатан байдал, суралцагчийн хэрэгцээ шаардлага зорилгод анхаарал тавьж ажилладаг, боломжит сонголт хувилбаруудад нээлттэй ханддаг.

Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж бүхий багш суралцагчийн суралцах үүрэг хариуцлага, санаачлагыг дэмжиж ажилладаг. Суралцагчийг бие дааж суралцах арга барил эзэмшүүлэх

зорилго тавьдаг ба тэднээр гүйцэтгэн хийлгүүлнэ. Ийм хэв шинжийн багш суралцагчийн өөртөө итгэх итгэлцэл, мэргэжлийн хөгжилд хувь нэмэр оруулдаг байна (Болор-Эрдэнэ нар, 2013, х.152, 153).

Судалгааны хэсэг

Энэхүү судалгаагааг багш нарын багшлахуйн хэв шинжийг тодорхойлж дүн шинжилгээ хийх зорилготой явууллаа. Судалгааг А.Ф.Грашагийн 40 асуулт бүхий асуулгаар авсан бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн багш нар өөрийн үйл ажиллагааг үнэлэх байдлаар судалгааны асуултад хариуллаа.

Багшлахуйн арга барил

Зорилго: Багш нарын багшлахуйн төрөл хэв маягийг тодорхойлж дүн шинжилгээ хийх

1. Судалгаанд оролцогчийн талаарх мэдээлэл: *хүйс..... ажилласан жил:.....*

ямар мэргэжлийн багш..... одоо ажиллаж буй сургууль.....

Таны багшлах арга барилтай холбоотой асуултаудыг дор дурдлаа. Өгөгдсөн түвшинг ашиглан 40 асуулт бүрд зөв хариулт өгнө үү?

1	3	4	5	7
Санал огт нийлэхгүй байна	Зарим нэг байдлаар санал нийлэхгүй байна	Санал нийлэх, нийлэхгүйн аль нь ч биш	Зарим нэг байдлаар санал нийлж байна	Бүрэн дүүрэн байдлаар санал нийлж байна

№	Асуулт	Оноо
1	Мэдээ, баримт, үзэл баримтлал аливаа зарчмууд нь суралцагчийн эзэмших хамгийн чухал зүйлс мөн	
2	Хичээл дээр сурагчдад стандарт шаардлагыг би өндөр тогтоодог	
3	Сурагчдад агуулгын хүрээнд бэрхшээлтэй асуудлыг бодох, сэтгэх замаар ойлголт өгөхийн тулд тайлбарлаж ярьдаг ба түүнд чиглэсэн тохиромжтой арга замаар жишээ загвар ашигладаг	
4	Би хичээл заахдаа сурагчдын суралцах хэлбэрийг харгалзан тохирсон арга барилыг ашигладаг	
5	Сурагчид ихэвчлэн миний зүгээс зааварчилга маш бага авч бие даан хичээлээ хийдэг	
6	Өөрийн мэдлэг туршлагаа сурагчидтай хуваалцах нь надад маш чухал	
7	Сурагчид хийж гүйцэтгэсэн ажилдаа хангалтгүй дүн үзүүлсэн үед би сөрөг санал зөвлөмж, шүүмж хэлдэг	
8	Сурагчид миний өгсөн жишээг дуурайж хийж болно	
9	Сурагчдын бие даалтын болон багаар эсвэл ганцаар хийж буй төсөлт ажлыг хэрхэн сайжруулах талаар тэдэнтэй зөвлөлдөх цаг гарган ажилладаг	
10	Хичээл дээр сурагчдыг багаар болон бие дааж ганцаарчлан ажиллахыг дэмждэг	
11	Миний заасан хичээл сурагчдын хувьд тухайн салбар дахь асуудлаар өргөн цар хүрээтэй дэлгэрэнгүй чиг баримжаа олж авахад нь тусална.	
12	Сурагчид миний тогтоосон стандарт тэднээс хүсэн хүлээж буй хүлээлт шаардлагыг хатуу чанд гэж тодорхойлно	
13	Хичээлийнхээ агуулгыг ойлгуулж эзэмшүүлэхийн тулд юуг, яаж хийхийг би ихэвчлэн хийж үзүүлдэг	

14	Сурагчдад бүтээлчээр сэтгэн бодох чадвараа хөгжүүлэхэд нь туслах зорилгоор “багаар” хувааж хэлэлцүүлэг явуулдаг	
15	Сурагчдад бие даан өөрийгөө хөгжүүлж сурах арга барил бий болгодог	
16	Энэ хичээлийг судалснаар сурагчид маань ирээдүйд аливаад сайн бэлтгэгдэж гараасай гэж би хүсдэг	
17	Сурагчид юуг үзэж судлах ёстой болон хэрхэн суралцахыг тодорхойлох нь миний үүрэг	
18	Үзэж буй хичээлийг ойлгуулах нь миний үүрэг	
19	Асуулт асуух бусад хувилбарыг олж илрүүлэх, боломжит хувилбарыг санал болгох хэлбэрээр би сурагчдад бие даах ажил хийхэд нь удирдан чиглүүлдэг	
20	Сурагчдын бие даан ажиллах болон сэтгэх чадварыг хөгжүүлэх нь хамгийн чухал зорилго	
21	Би хичээл заахдаа лекцийн хэлбэрийг чухалчлан үздэг	
22	Хичээлийн явцад ажилбар даалгаврыг хэрхэн гүйцэтгэх талаар би маш тодорхой зааварчилгаа өгдөг	
23	Төрөл бүрийн зарчим, үзэл баримтлалыг хэрхэн ашиглаж болохыг би сурагчдад ихэвчлэн өөрөө хийж үзүүлдэг	
24	Хичээлийн үйл ажиллагаа нь сурагчдыг өөрсдийн суралцах үйл ажиллагаанд хариуцлагатай хандаж санаачлагатай байхад уриалан дууддаг	
25	Суралцагчид хичээлийн явцад заан сургах ажиллагаанд хариуцлага хүлээдэг	
26	Хичээлийн агуулгатай холбоотой асуудлаар санал зөрөлдсөн үед би өөрийн туршлагаа гол төлөв ашигладаг	
27	Бүлэг сэдвээр хүрэх гэсэн зорилго зорилт маань маш тодорхой томъёологддог	
28	Суралцагчдын сурлагын үзүүлэлтэнд аман болон эсвэл бичгээр тогтмол санал зөвлөмж өгч тэдний хүсэлтийг ажилдаа бас тусгадаг	
29	Би суралцагчдаас хичээл дээр юуг яаж заах талаар санал хүсэлтийг авч тусгадаг	
30	Сурагчид бие даасан болон багийн судалгааны ажлаа хийж дуусахдаа өөрсдөө ажлын гүйцэтгэлийн хурд, түвшингээ тогтоодог	
31	Сурагчид намайг баримт мэдээллийг түгээн дэлгэрүүлж байдаг “оюуны их уурхай” гэж тодорхойлж магадгүй	
32	Сурагчдаар хичээлийн явцад юу хийлгэх талаар хөтөлбөртөө тодорхой тусгадаг	
33	Сургалт үргэлжлэх явцад олон суралцагч хичээлийн агуулгын талаар надтай ижил бодож эхэлдэг гэж би боддог	
34	Суралцагчид хичээлийн шаардлагыг хангахын тулд үйл ажиллагаануудаас сонгон ажиллах боломжтой	
35	Миний сургах арга нь өөрийн удирддаг хүмүүстээ үүрэг хариуцлагыг нь хуваарлин ноогдуулж ажилладаг менежертэй адилхан	
36	Бүлэг сэдвээр сурагчдын судлах материал миний заах боломжит цагаас илүү их байдаг	
37	Сурагчид суралцахын тулд сахилга баттай байж сурахад нь миний тогтоосон шаардлага тусалдаг	
38	Яаж бодож, хэрхэн биеэ авч явах талаарх алдаагаа засахад нь ойр дотно тусалж ажилладаг “дасгалжуулагч багш” гэж сурагчид маань намайг тодорхойлох байх	
39	Шавь нар маань хичээлдээ амжилттай сайн суралцахад нь хувь хүнийхээ хувьд ихээхэн дэмжиж урам өгч ажилладаг	
40	Сурагчдад тусламж хэрэгтэй үед нь туслах үүрэгтэй хүн бол туслах ажилтан гэж би ойлгодог	

Судалгааны боловсруулалтын хэсэг

А. Судалгаанд оролцогчдын талаарх мэдээллийн хэсэг

Судалгаанд Улаанбаатар хотын ерөнхий боловсролын 33, 48, 53, 57, 79, 97, Булган аймгийн Дашинчилэнгийн ЕБС, Сэлэнгэ аймгийн Хэрх сумын 4-р сургуулийн эрэгтэй 25 багш 33,3%, эмэгтэй 50 багш 66,7% нийт 75 багш оролцсон.

1. Багш нарыг ажилласан жилээр нь авч үзвэл:

- 1-5 жил 24 багш буюу 32%
- 6-10 жил 12 багш буюу 16%

- 11-15 жил 19 багш буюу 25,3%
 - 16-20 жил 8 багш буюу 10,7%
 - 21-25 жил 4 багш буюу 5,3%
 - 25 –аас дээш жил 8 багш буюу 10,7%
2. Багш нарын мэргэжлээр авч үзвэл:

- Газарзүй багш 14,7%
- Монгол хэл, У/З багш 12%
- Гадаад хэлний багш 12%
- Биологийн багш 10,7%
- Математик багш 9,3%
- Түүх нийгэм багш 9,3%

- Бага ангийн багш 8%
- Биеийн тамир багш 6,7%
- Физик багш 6,7%
- Мэдээлэл зүй багш 4%
- Хими багш 4%
- Технологи багш 1,3%
- Эрүүл мэнд багш 1,3%

Б. Судалгааны боловсруулалтын хэсэг

Хүснэгт 1

Багшийн хэв шинжийн түвшин

№	Багшийн хэв шинж	Бага		Дундаж		Өндөр	
		Сонголтын тоо	Эзлэх хувь	Сонголтын тоо	Эзлэх хувь	Сонголтын тоо	Эзлэх хувь
1	Шинжээч хэв шинж	2 багш	2,7%	18 багш	24%	55 багш	73,3%
2	Албархаг хэв шинж	5 багш	6,7%	39 багш	52%	31 багш	41,3%
3	Үлгэрлэгч хэв шинж	6 багш	8%	50 багш	66,7%	19 багш	25,3%
4	Туслан дэмжигч хэв шинж	5 багш	6,7%	39 багш	52%	31 багш	41,3%
5	Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж			14 багш	18,7%	61 багш	81,3%

1. Судалгаанд хамрагдсан 1-5 жил ажиллаж буй 24 багш нарын 62,5% нь эмэгтэй, 37,5% нь эрэгтэй багш нар байна. Багшийн хэв шинжийг авч үзвэл:

- Шинжээч хэв шинж: бага 4,2%, дундаж 20,8%, өндөр түвшинд 75%,
- Албархаг хэв шинж: бага 4,2%, дундаж 58,3%, өндөр түвшинд 37,5%,
- Үлгэрлэгч хэв шинж: бага 4,2% дундаж, 66,7%, өндөр түвшинд 29,2%,
- Туслан дэмжигч хэв шинж: бага 8,3%, дундаж 54,2%, өндөр түвшинд 37,5%,
- Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж: дундаж 16,7%, өндөр түвшинд 83,3% байна.

2. Судалгаанд хамрагдсан 6-10 жил ажиллаж буй 12 багш нарын 58,3% эрэгтэй, 41,7% эмэгтэй багш нар байна. Багшийн хэв шинжийг авч үзвэл:

- Шинжээч хэв шинж: дундаж 16,7%, өндөр 83,3%
- Албархаг хэв шинж: бага 25%, дундаж 25%, өндөр 50%
- Үлгэрлэгч хэв шинж: бага 16,7%, дундаж 50%, өндөр 33,3%
- Туслан дэмжигч хэв шинж: дундаж 50%, өндөр 50%
- Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж: өндөр түвшинд 91,7% байна.

3. Судалгаанд хамрагдсан 11-15 жил ажиллаж буй 19 багшийн хэв шинжийг авч үзвэл:

- Шинжээч хэв шинж: дундаж 47,4%, өндөр 52,6%
- Албархаг хэв шинж: дундаж 68,4%, өндөр 26,3%
- Үлгэрлэгч хэв шинж: дундаж 78,9%, өндөр 15,8%
- Туслан дэмжигч хэв шинж: дундаж 63,2%, өндөр 31,6%

• Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж: өндөр 73,7%

4. Судалгаанд хамрагдсан 16-20 жил ажиллаж буй 8 багшийн хэв шинжийг авч үзвэл:

- Шинжээч хэв шинж: өндөр 87,5%,
- Албархаг хэв шинж: өндөр 37,5%, дундаж 62,5%,
- Үлгэрлэгч хэв шинж: бага 25%, дундаж 62,5%, өндөр 12,5%,
- Туслан дэмжигч хэв шинж: бага 25%, дундаж 37,5%, өндөр 37,5%,
- Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж: дундаж 25%, өндөр түвшинд 75% байна.

5. Судалгаанд хамрагдсан 20-25 жил ажиллаж буй 4 багшийн хэв шинжийг авч үзвэл:

- Шинжээч хэв шинж: бага 25%, дундаж 25%, өндөр 50%,
- Албархаг хэв шинж: дундаж 50%, өндөр 50%,
- Үлгэрлэгч хэв шинж: дундаж 75%, өндөр 25%,
- Туслан дэмжигч хэв шинж: дундаж 50%, өндөр 50%,
- Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж: дундаж 25%, өндөр түвшинд 75% байна.

6. Судалгаанд хамрагдсан 25-с дээш жил ажиллаж буй 8 багшийн хэв шинжийг авч үзвэл:

- Шинжээч хэв шинж: 100% өндөр түвшинд
- Албархаг хэв шинж: дундаж 25%, өндөр 75%
- Үлгэрлэгч хэв шинж: дундаж 62,5%, өндөр 37,5%
- Туслан дэмжигч хэв шинж: дундаж 37,5%, өндөр 62,5%
- Бусдаар гүйцэтгүүлэгч хэв шинж: өндөр 87,5% тус тус хариулсан байна.

ДҮГНЭЛТ

А.Ф.Грашагийн 40 асуулт бүхий асуулгаар авсан судалгааг боловсруулахад:

1. Судалгаанд оролцсон нийт багш нарын багшлах хэв шинж нь Албархаг-52%, Туслан дэмжигч-52%, Үлгэрлэх-66,7%, хэв шинжийн “Дундаж түвшин”-д байна. Энэ нь: Суралцагчийнхаа дунд мэдлэг болон эрх мэдэл бүхий албан тушаалаараа нэр хүнд байр сууриа олж авдаг. Сургалтаа явуулахдаа стандартыг дагаж мөрддөг, дүрэм журамд илүү их ач холбогдол өгдөг. Хувь хүний уян хатан байдал, суралцагчийн хэрэгцээ шаардлага зорилгод анхаарал тавьж ажилладаг нь харагдаж байна.

2. Шинжээч-73.3%, Бусдаар гүйцэтгүүлэгч-81,3% хэв шинжийн “Өндөр түвшин”-д байна. Энэ нь: Багш мэргэжлээр 1-10 болон 11-20 жил ажиллаж байгаа багш нар мэдлэг туршлагатай, суралцагчдаа хянаж, тэднийг удирдан чиглүүлдэг, дэмждэг, баримт мэдээлэлд илүү тулгуурлан, өөртөө итгэх итгэлцэл, мэргэжлийн хөгжилд хувь нэмэр оруулан ажиллаж байгаа нь өндөр түвшинд байгаа нь харагдаж байна. Мөн суралцагчийн үйл ажиллагаа үйлдэл, алхам бүрийг хэрхэн биелүүлж буйд шүүмжлэлтэй хандаж, асуудалд уян хатан биш, нилээд хатуу чанга хандах, зарим тохиолдолд мэдлэгээ хэтрүүлэн ашиглах зэрэг нь суралцагчдад айдас төрүүлдэг байх магадлалтай байна.

3. Багш мэргэжлээр 25-аас дээш жил ажилласан багш нарын хувьд Шинжээч-100%, Бусдаар гүйцэтгүүлэгч-87,5%, Албархаг-75% хэв шинж тус тус “Өндөр” түвшинд байна. Багш мэргэжлээр 25-аас дээш жил ажиллаж байгаа багш нарт дээр дурдсан хэв шинж илүү өндөрт түвшинд байгаа нь харагдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Grasha, A. F. (1984). Learning styles: The journey from Greenwich Observatory (1796) to the college classroom (1984). *Improving College and University Teaching* 32:46-53.
- Grasha, A. F. (1990). Using traditional versus naturalistic approaches in assessing learning styles in college teaching. *Journal on Excellence in College Teaching* 1, 23-28.
- Grasha, A. F. (1992). A matter of style. The teacher as expert, formal authority, personal model, facilitator and delegator. *College teaching*. Vol 42, No4, p 142-149
- Hruska-Riechmann, S., A. F. Grasha. (1982). The Grasha-Riechmann student learning style scales: Research findings and applications. JKeefe Ed, *In Student learning styles and brain behavior*. Reston, VA: NASSP.
- Reinsmith, W. A. (1992). *Archetypal forms in teaching: A continuum*. Westport, Conn.: Greenwood Press.